



МОНГОЛ УЛС  
ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН  
ЗАХИРАМЖ

2021 оны 02 сарын 18 өдөр

Дугаар А/63

Мандалговь

Техникийн хяналтын үзлэг, тээврийн  
хэрэгслийн шинэчилсэн бүртгэлийг  
явуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6 "а", "Автотээврийн тухай" хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.2, 17 дугаар зүйлийн 17.1, 17<sup>1</sup>.1 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Тээврийн хэрэгслийн техникийн хяналтын 2021 оны үзлэг, шинэчилсэн бүртгэлийн ажлыг зохион байгуулах аймгийн комиссыг нэгдүгээр, сумдад ажиллах комиссыг хоёрдугаар, үзлэгийн хуваарийг гуравдугаар хавсралтаар баталсугай.

2. Аймгийн хэмжээнд бүртгэлтэй нийт тээврийн хэрэгслийг техникийн хяналтын үзлэгт хамруулах үйл ажиллагааг жилийн турш жигд, чанартай зохион байгуулж, холбогдох стандартуудын шаардлагыг хангуулах, гаалийн бүрдүүлэлттэй мотоциклыг бүртгэлжүүлэх, ашиглах боломжгүй тээврийн хэрэгслийг улсын бүртгэлээс хасуулах ажлыг зохион байгуулахыг Автотээврийн төвийн дарга (Ц.Хүрэлбаатар)-д үүрэг болгосугай.

3. Тус аймгийн иргэд байгууллагын эзэмшилд бүртгэлтэй байгаа автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, агаарын бохирдлын төлбөр, орон нутгийн авто зам ашигласны төлбөр хураамжийг холбогдох хууль, тогтоомжийн дагуу 06 сарын 01-ний дотор хураан төсөвт төвлөрүүлэхийг Татварын хэлтсийн дарга (М.Туяацэцэг)-т үүрэг болгосугай.

4. Техникийн хяналтын үзлэгт сумынхаа албан байгууллага, иргэдийн болон нутаг дэвсгэртээ үйл ажиллагаа явуулж байгаа уул уурхайн компаниудад урьдчилан мэдэгдэж, үзлэг оношилгоо зохион байгуулах байрны бэлэн байдлыг хангуулж ажиллахыг сумдын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

5. Техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэлд хамрагдсан байдал, автотээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар, орон нутгийн авто зам ашигласны төлбөр төлөлт, жолоочийн хариуцлагын даатгалд хамрагдсан байдалд бүтэн жилийн турш хяналт шалгалтыг тасралтгүй хийж, зөрчлийг тухай бүр арилгуулахыг аймгийн цагдаагийн газрын дарга, хурандаа (Г.Наранбаатар), Мэргэжлийн хяналтын газрын дарга (Ш.Төрбат), автотээврийн болон замын хөдөлгөөний аюулгүй байдлын хяналтын улсын байцаагч, зохицуулагч нарт үүрэг болгосугай.

6. Техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, татвар хураалтын үйл ажиллагааг орон нутагт зохион байгуулж ажилласан дүн мэдээг үндэслэн сумдын Засаг дарга нарын үр дүнгийн гэрээний биелэлтэд үнэлэлт

481210157

дүгнэлт өгч ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын Хяналт шинжилгээ үнэлгээ, дотоод аудитын хэлтсийн дарга (Г.Самданцоодол)-д даалгасугай.

7. Техникийн хяналтын үзлэг, тээврийн хэрэгслийн шинэчилсэн бүртгэл, татвар төлөлтийн үйл ажиллагаанд хяналт тавьж, ажлын үр дүнг улирал тутамд танилцуулж ажиллахыг Автотээврийн төвийн дарга (Ц.Хүрэлбаатар), Татварын хэлтсийн дарга (М.Туяацэцэг), Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого, төлөвлөлтийн хэлтсийн дарга (Н.Эрдэнэ-Очир) нарт тус, тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.МӨНХБАТ